Дулааны үйлчлэл: - Энэ нь цахилгаан гүйдлийн нөлөөгөөр биеийн зарим хэсэгт, мэдрэлийн эд эсүүд халах, түлэгдэх, нүүрсжиж зэрэг болно.

Электрорлитийн үйлчлэл нь цахилгаан гүйдлийн нөлөөгөөр хүний биеийн органик шингэн, тухайлбал цус, электролизд орж задрах явдал юм.

Биологийн үйлчлэл: - Энэ нь цахилгаан гүйдлийн улмаас организмийн амьд эд эс, бүлчин цорох, дотоод бие цахилгаан процесс зөрчилдөх явдал юм.

Механик (динамик) үйлчлэл: -Энэ нь мэдрэлийн судал, судас, арьс тасарч, язрах үе мултрах, яс хугарах зэрэг юм.

Хүн цахилгаан гүйдэлд өртөх байдлыг ерөнхийд нь цахилгаан гэмтэл, цахилгаанд цохиулах гэж 2 бүлэг болгон ангилж болно.

Цахилгаан гэмтэл гэдэг нь: - Цахилгаан гүйдэл болон цахилгаан нумын

үйлчлэлээр организмийн эд эсүүд гэмтэж бэрххийг хэлнэ. Цахилгаан гэмтэл нь түлэгдэлт, цахилгаан тэмдэг үүсэх, арьс металлжих, механик гэмтэл гэсэн

хэлбэртэй байна.

Цахилгаан түлэгдэлт нь хүний биеэр 1А-аас илүү хүчтэй гүйдэл дамжсан үед

биеийн эдийн халаалтаас үүсдэг. Түлэгдэлт нь арьсны гадаргууг гэмтээсэн

гадаргын биеийн эдийн дотоод хэсгийг гэмтээсэн гүний, мөн үүссэн нөхцлөөрөө

нумын, гүйдлийн (эсвэл контактын) хосолсон түлэгдэлт гэж байдаг.

Цахилгаан тэмдэг үүсэх: Энэ нь цахилгаан гүйдэлд өртсөн хүний арьсны

гадаргуу дээр саарал, эсвэл бүдэг шар өнгөний дугуй, эсвэл зууван хэлбэртэй 1-5 мм хэмжээтэй тогтоо үүсдэг. Зарим тохиолдолд шарх маажуулсан буюу зүсэгдсэн

юм шиг эсвэл аянвгын хэлбэртэй ч байдаг. Цахилгаан тэмдэг нь өвчин зовиургүй

Арьс цахилгаанаар металлжих: Энэ нь цахилгаан нумын нөлөөгөөр үүссэн металлын ууршсан эгэл хэсгүүд хүний арьсны гадаргууд үйлчилж уг металлын өнгөөр нэвчихийг хэлнэ. Арьс металлжих нь бага зэрэг зовиуртай боловч аюулгүй, ваанадаа эдгэрч арилдаг. Харин нүд нингэж металлжих нь аюултай юм. Тийм учраас цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиглагдаг ажилтан нүдний хамгаалах шил хийх шаардлагатай.

• **Механик эмтэл нь :** Энэ нь цахилгаан гүйдлийн нөлөөгөөр бүлчин ороом ашиж арьс эвэрх, задрах, судас, мэдрэлийн судал тасрах, үе мултрах, яс хугарах зэрэг механик гэмтэл үүсэх юм. Мөн цахилгаан нумын ултра явгана туяанг нөлөөгөөр үүд үрэвсчих явдал элбэг тохиолддог.

Цахилгаанд цохуулах : Энэ нь цахилгаан гүйдлийн нөлөөгөөр амьд элд цочирч, бүлчин өөрийн эрхгүй татвалзан аших улмаар зүрх уушиг төв мэдрэлийн систем зэрэг эрхтэний системийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж бүх организм аюулд учирхыг хэлнэ. Цахилгаанд цохуулахыг түүний хүнд, хөнгөний байдалаас хамааруулан дараах 5 зэрэгт ангилж үздэг.

- ❖ Бүлчингийн мэдрэгдэх төдийд таталцан ашиглт
- ❖ Ухаан алдахгүй боловч тэсвэрлэхэд бэрх өвдөлт үүсгэх бүлчингийн таталцсан ашиглт
- ❖ Амьсгал зүрхний үйл ажиллагаа хадаглалтад боловч ухаан алдах, бүлчингийн таталцсан ашиглт
- ❖ Амьсгал зүрхний үйл ажиллагаа алдагдаж ухаан алдах
- ❖ Амьсгал зүрхний үйл ажиллагаа алдагдаж ухаан алдах

Клиникийн буюу хуурамг үхэл эдгээг нь амьдарлаас үхэлд шилжих шилжилтийн үед юм.

Клиникийн үхлийн шинж тэмдэг нь амьсгал зогссоноос тархны бор давхрага хүчлгтөрөгчийн дутагтад орж хүүхэн хараа эрс тэлж томрон гэрэл мэдрэхгүй. Зүрх зогссон буюу зүрхний фибриллаци болсноос судас лүгшхаа болно. Энэ байдал 6-8 минут үргэлжилэх ба уг хугацаа дуусмагц, тархны бор давхаргын эс үхэн амьдрал дуусц биологийн үхэлд хүрнэ. Зүрхний фибриллаци гэдэг нь цахилгаан гүйдлийн үйлчлэлийн улмаас зүрхний цохилгын хэвийн хэмээлт алдагдаж зүрхний бүлчингийн олон ширхэгийн эмх замбараагүй давтагдан таталцан байдалд орохыг хэлнэ. Ийм таталгын давтамж нь 500-700 удаа байдаг ба хэвийн хэмэнийнхээс даруй арав гаруй дахин ихэсэж цус шахахаа болно. Энэ нь үхэлд хүргэх аюултай.

Цахилгаан цохилулах үед тохиолдож болох хүнд хэлбэр нь цахилгаан дайрлага шок юм.

Цахилгаан дайрлага гэж цахилгаан гүйдлийн үйлчлэлээс үүссэн организмзын мэдрэл-рефелексийн хүнд хариу урвалыг хэлнэ. Цахилгаан дайрлагын үед амьсгал, цусны эргэлт, мэдрэлийн болон организмзын бусад систем гүн сарнилд орно.

Цахилгаан ослын хүндрэлд нөлөөлөх хүчин зүйлүүд

Цахилгаан ослын хүндрэл нь маш олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд тэдгээрээс заримыг авч үзье.

1. **Гүйдлийн хүч**: Хүн цахилгаан гүйдэлд өртсөнөөс ослдох үндсэн хүчин зүйл нь хүний биеэр дамжсан гүйдлийн хүч юм. Гүйдлийн хүч өссөнөөр сөрөг нөлөөллийн зэрэг буюу аюул улам ихэснэ. Гүйдлийн хүчний организмд сөрөгөөр нөлөөлөх байдлыг талар ОХУ, АНУ, Герман болон бусад олон улсын эрдэмтэд өргөн судалгаа явуулдаг боловч нэгдсэн нэг ойлголтонд хүрч чадаагүй байна.

Хүний биеэр дамжих гүйдлийг дараах байдлаар ерөнхийд нь ангилж үзнэ.

- ✓ Мэдрэх гүйдэл – хүний биеэр дамжих мэдрэгдэх хэмжээний чорлол үүсгэж байгаа гүйдлийг мэдрэх гүйдэл гэх бөгөөд энэ гүйдлийн хамгийн бага утгыг мэдрэх гүйдлийн босго гэнэ.
- ✓ Зуурах гүйдэл – хүн гартаа барьсан электродоос өөрөө чөлөөлөгдөж чадаргүй болж гарын булчирхайн таталдсан ашгилт үүсэх гүйдлийг зуурах гүйдэл гэх бөгөөд энэ гүйдлийн хамгийн бага утгыг зуурах гүйдлийн босго гэнэ.
- ✓ Фибриллацийн гүйдэл – хүний биеэр дамжих зүрхний фибриллацийн үүсгэх гүйдлийг фибриллацийн гүйдэл гэх бөгөөд энэ гүйдлийн хамгийн бага утгыг фибриллацийн босго гэнэ.

2. **Гүйдлийн үүлчлэх хүчээр**: - цахилгаан ослд хйсан судалгаагаар цахилгаан гүйдэл хүний биеэр дамжих хүчээр аюул улам нэмэгддэгийг тогтоожээ. Орчин үед цахилгаан гүйдлийн аюулын түгээмэл хэрэглэгдэж байгаа хязгаар нь 3 сек–ийн хугацаатай, 100А-ийн гүйдэл юм.

3. **Хүний биеийн цахилгаан эсэргүүцэл**: - хүний биеийн цахилгаан эсэргүүцэл нь хүний биеийн эд, арьсны бүтэц, байдал, бохирдолт, физиологийн болон хүрээлэн байгаа орчны гэх мэт олон хүчин зүйлээс хамаарана.

4. **Гүйдэл дамжсан зам**: - цахилгаан ослд хйсан түршилт, судалгаанаас үзэхэд гүйдэл дамжсан зам ослын хүндэргийн байдалд чухал нөлөөтэй. Хүний биед цахилгаан гүйдэл дамжих боломжтой хэд хэдэн зам байдгаас бүү цахилгаан ослын 40% нь гар-гар, 20% нь баруун гар –хөл, 17% нь зүүн гар –

хөл, 6% нь хөл-хөл, 5% нь толгой –хөл, 4% нь толгой –гар, 8% нь бусад замд тус тус ногдож байна.

ЦАХИЛГААН ТОНОГ ЛОЛЫН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

1. Хамгаалах газардүүлгэ

2. Нойтлуулгэ

3. Хамгаалах тасралт

4. Цахилгаанаас хамгаалах хэрэгсэл

5. Цахилгаан гүйдэлд нэрвэгдэхийг үзүүлэх анхны тусламж

Цахилгаан тоног төхөөрөмжид ажиллаж байгаа хүнийг цахилгааны аюулаас хамгаалах арга хэмжээг 2 бүлэг болгон хуваадаг.

1. Цахилгаан тоног төхөөрөмжийн **ажлын хэвцэн** аюулгүй ажиллагааг хангах. Үнд гүйдэл дамжуулах хэсгийг тусгаарлах буюу хүрээхээрүй болгох, аюулгүй ажиллагааны хориг түгжээ хэрэглэх, цахилгаан сүлжээг газраас тусгаарлах, газардлагын гүйдлийн багтаамжийн гүйдлүүлэгчийг компенсацилах, хамгаалах холболт хийх, бага хүчдэл хэрэглэх, тусгаарлах тавцан хэрэглэх, потенциалыг тэгшитгэх арга хэмжээнүүд хамрагдана.

2. Цахилгаан тоног төхөөрөмжийн **аваарын зорилго** (цахилгаан тусгаарлалт гэмтэх, эвдрэх, гүйдэл дамжуулахад зориулагддаг хэсэгт хүчдэл шилжих гэх мэт) аюулгүй ажиллагааг хангах. Үнд хамгаалах газардүүлгэ, нойтлуулгэ, хамгаалах тасралт, давхар тусгаарлалт, өндөр хүчдэлийн нам талд шилжихээс хамгаалах зэрэг хамгаалалтын арга хэмжээнүүд хамрагдана.

Цахилгаан тоног төхөөрөмжийн төрөл, саармагийн горим, номинатор хүчдэл зэрэг тэжээлийн нөхцөл, хүрээлэн байгаа орчны болон үйлдвэрлэлийн технологийн зэрэг ашиглалтын нөхцлөөс хамаруулан цахилгааны аюулгүй ажиллагааг хангах голчлолдор арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1. Хамгаалах газардүүлгэ

Газар болон түүний эквиваленттай зориудын цахилгаан холболт бий болгохыг газардүүлгэ гэх ба газардүүлгэлт нь цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллагсдыг цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, цахилгааны осол аваараас хамгаалах хамгаалалт юм.

Газардүүлгэ ба хамгаалах газардүүлгэ гэж 2 ангилдаг. Байгалийн газардүүлгэд газартай байнга холбоотой байдаг барилгын төмөр бетон болон үйлдвэрлэлийн хийц ордог бол хамгаалах газардүүлгэ гэдэг нь цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлтэй болж болзошгүй, гүйдэл дамжуулахад зориулагддаг төмөрлөг хэсгүүдийг газар буюу түүний эквиваленттай зориудын цахилгаан холболт бий болгохыг хэлнэ. Газардүүлгэд цахилгаан машин, аппарат, трансформатор, гаралтүүлэгчийн хийц, хуваарилга самбар, шүүгээний яс төмөр, кабелийн холбох муфт, металл хийц, цахилгаан дамжуулах утасны металл хоолой зэрэг гүйдэл

дамжуулахад зориулагдаг боловч тусгаарлаг гэмтсэний улмаас хүчдэлтэй болж болзошгүй металл хэсгүүдийг хамаруулна.

Газардуулагч гэж газардуулагч ба газардуулагчын дамжуулагчаас бүрдсэн хийцийн нэгдлийг хэлнэ. Газардуулагч гэдэг нь газар болон түүнийг эквиваленттай сайтар холбогдсон металл дамжуулагчүүдийн нэгдлийг хэлнэ. Газардуулагч гэдэг нь цахилгаан тоног төхөөрөмжийн газардуулах хэсгийг газардуулагчтай холбосон дамжуулагч юм. Хэрэв газардуулагчын дамжуулагч 2, түүнээс дээш салаатай байвал түүнийг газардуулагчын магистрал дамжуулагч гэнэ. Газардуулагч ба газардуулагч байгаа тоног төхөөрөмжийн харилцан байрших байдалаараа газардуулагчын байгууламж нь алслагдсан ба хүрээ гэж хоёр янз байна.

2 Нойлтуулга

Нойлтуулга гэж цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлтэй болж болзошгүй, гүйдэл дамжуулахад зориулагдагуй металл хэсгийг шууд газардуулсан саармалтай сүлжээний нойлын дамжуулагчтай зориулдаг цахилгаан холболт бий болохыг хэлнэ. Нойлтуулгын бүдүүвч нь дараарх элементүүдээс бүрдэнэ. Үнд:

Нойлын дамжуулагч. Энэ нь сүлжээний фаз их биед холбогдох үед нэг фазын богино холбооны гүйдлээр найдвартай ажиллах боломжийг хангасан бага эсэргүүцэл бүхий хэлхээ үүсгэх зориулалттай.

Тэжээлийн үүсгүүрчин саармалын газардуулга. Энэ нь сүлжээний фаз газардсан үед нойлын дамжуулагчийн газартай харьцангуй хүчдэлийг бага байлгах үүрэгтэй.

Нойлын дамжуулагчийн дагхан газардуулга. Энэ нь нойлын дамжуулагчийн үрчин дагуу тодорхой зайд хийгдэх бөгөөд гэмтэл эвдрэлтэй тоног төхөөрөмжийг таслахад нөлөө үзүүлэхгүй боловч сүлжээний хэвийн горимд фаз их биед холбогдох болон нойлын дамжуулагч тасарсан үед нойлын дамжуулагч ба нойлтуулгадсан тоног төхөөрөмжийн газартай харьцангуй хүчдэлийг бага байлгах үүрэгтэй.

3 Хамгаалах таслалт

Хамгаалах таслалт гэж хүн цахилгаан гүйдэлд өртөх аюултай нөхцөл бий болсон үед цахилгаан тоног төхөөрөмжийг богино хугацаанд автоматаар таслах хамгаалах таслалтыг хэлнэ. Хамгаалах таслалтын байгууламжийн үндсэн элементүүдэд хамгаалах таслалтын ба гүйцэтгэх элемент буюу автоматад таслуурууд орно.

Хамгаалах таслалтын багаж нь өөрөө оролтын хэмжигдэхүүнийг мэдрэх, түүний өөрчлөлтөө ажиглах, тодорхой утганд таслуурт дохио өгөх болон бусад хянах туслах элементүүдээс бүрдэнэ.

1. Дамжигч нь оролтын хэмжигдэхүүнийг мэдрч дараагийн элементэд тохиромжтой дохио болгон хувиргах оролтын хэсэг юм. Дамжигч нь янз бүрийн релэ, өсгөчийн оролт, хэмжүүрийн трансформатор, тэг дарааллын гүйдлийн филтр зэрэг байна.

2. Өсгөгч нь датчигийн гаргаж ирсэн дохио чадал багатай байвал түүнийг өсгөхөд зориулагдана. Үг дохио гүйцэтгэх элементэд өгөгдөх болно. Зарим

хамгаалах таслалтын багажийн хувьд датчикийн гаралтын хэмжигдэхүүн хүрэлцэхүйц чадалтай байдаг тул өсгөгч хэрэглэх шаардлагагүй.

3. *Хяналтын хэлхээ* нь хамгаалах таслалтын бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хянахад зориулагдсан хэлхээ юм.

4. *Туслах элементүүд* нь цахилгаан тоног төхөөрөмжийн байдлыг тодорхойлох дохионы гэрэл, хэмжүүрийн багаж зэрэг болно.

Гүйцэтгэх элемент нь хамгаалах таслалтын багажаас дохио ирсэн үед цахилгаан тоног төхөөрөмж буюу сүлжээний хэсгийг таслах автомат таслуур юм. Гүйцэтгэх элементийн үүргийг контактор, соронзон асаагуур, автомат, хамгаалах таслалтын байгууламжид зориулагдсан тусгай таслуур, өндөр хүчдэлийн (тосон, вакуум) таслуур гүйцэтгэнэ. Хэрэглэх хүрээ нь хязгааргүй юм. Орчин үед хамгаалах таслалтыг сүлжээний тусгаарлалтын эсэргүүцэл тодорхой хэмжээнээс буурах, фаз их биед холбогдох буюу газардах, хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэгт хүн хүрэх аюулгүй ажиллагааг хангах зорилгоор өргөн хэрэглэж байна.

4.Хамгаалах хэрэгсэл

Үндсэн хамгаалах тусгаарлах хэрэгсэл гэж тэдгээрийн тусламжтайгаар хүчдэлтэй байгаа гүйдэл дамжуулах хэсэгт хүрэхийг зөвшөөрдөг, ажлын хүчдэлийг найдвартай тусгаарлах хамгаалах хэрэгслийг хэлдэг.

Нэмэгдэл хамгаалах тусгаарлах хэрэгсэл гэж тухайн хүчдэлд ажилтны аюулгүй ажиллагааг дангаараа хангаж чадахгүй бөгөөд үндсэн тусгаарлах хэрэгсэлд нэмэлт арга хэмжээ болгож хэрэглэх тусгаарлах хамгаалах хэрэгслийг хэлнэ.

- **Хааж хориглох**
- **Туслах**

1000 В хүртэл хүчдэлд дараах хамгаалах хэрэгслүүдийг ашиглана. Үүнд:

1. Үндсэн тусгаарлах хамгаалах хэрэгсэл нь:

- Диэлектрик резинэн бээлий
- Тусгаарлах бариултай монторын багаж
- Хүчдэл заагуур
- Тусгаарлах бахь

2. Нэмэгдэл тусгаарлах хамгаалах хэрэгсэл нь:

- Диэлектрик бойтог, шаахай
- Диэлектрик дэвсгэр, зам
- Тусгаарлах гишгүүр

1000 В – оос дээш хүчдэлд дараах хамгаалах хэрэгс-лүүдийг ашиглана. Үүнд:

1. Үндсэн тусгаарлах хамгаалах хэрэгсэл нь:

- Тусгаарлах штанг
- Гүйдэл хэмжих бахь (кешш)
- Хүчдэл заагуур
- Тусгаарлах бахь

2. Нэмэгдэл тусгаарлах хамгаалах хэрэгсэл нь:

- Диалектрик бээлий
- Диалектрик бойтог
- Резинэн дэвсгэр, зам
- Шаазан тусгаарлагч гишгүүр

Зөөврийн газардуулаа нь цахилгаан дамжуулах шугам, тоног төхөөрөмжийн тэжээлийн үүсгүүрээс нь таслан ажил гүйцэтгэж байх үед алдаа гаргаж хүчдэл өгөх тохиолдлоос хааж хориглох хамгаалах хэрэгсэл юм. Зөөврийн газардуулаа нь гүйдэл дамжуулах хэсгүүдийг хооронд нь богино холбох ба түүнийгээ газардуулна. Зөөврийн газардуулаа тавих, авах үйлдлийг тусгаарлах бээлий, бойтог өмсөн тусгаарлах дэвсгэр, эсвэл гишгүүр дээр зорсож тусгаарлах штангийн тусламжтайгаар гүйцэтгэнэ.

Цахилгааны аюулас урьдчилан сэргийлэхэд ашиглагдах хааж хориглох хамгаалах хэрэгслийн төрөлд хамаарагдах **урьдчилан сэргийлэх плакат** нь анхааруулах, хориглох, зөвшөөрөх, сануулах гэсэн 4 төрөл байдаг бөгөөд "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм" – д заасан хэмжээ, хэлбэр, өнгө, таних дүрс, тэмдэг, тэмдэглэлтэй байна.

- **Анхааруулах плакат** нь ойртоход аюултай, хүчдэлтэй хэсэг байгааг анхааруулах зориулалттай бөгөөд байнгын ба зөөврийн гэсэн 2 янз байна. **Байнгын** анхааруулах плакатыг хураарилж байгууламж, дэд станц, таслуурын камерын хаалга, мөн агаарын шугамын тулгуур дээр бэхэлнэ. **Зөөврийн** анхааруулах плакатыг хаалт, эсвэл ажил гүйцэтгэж байгаа тоног төхөөрөмжийн дэргэдэх тоног төхөөрөмжид байрлуулдаг.
- **Хордогох плакат** нь зөөврийн плакат бөгөөд ажил гүйцэтгэж байгаа байр руу хүчдэл өгөх боломжтой тасгуур, тасгуур, үлдирдлэгийн тулгуур, унтраалга, барил, технологийн болон үлдирдлэгийн хий, шингэний шугам хоолойг хаасан хаалт, ажлын байрыг хязгаарласан хаалга, хаалт, хашилт дээр тавина.
- **Зөвшөөрөх плакат** нь зөөврийн плакат бөгөөд хуваарилах байгууламж, дэд станцын ажил гүйцэтгэхээр болгосон ажлын байранд, мөн үйлдвэрийн байран дотор цахилгааны хуваарилах самбар, кабели шугам, цахилгаан хөдөлгүүр зэрэг тоног төхөөрөмжид ажил гүйцэтгэхээр болгосон хэсэгт тавьж ажил гүйцэтгэгчид ажиглах байрыг нь зааж өгөх зориулалттай.

- **Сануулах плакат** нь мөн зөөврийн плакат бөгөөд ажиглагчид аюулгүй ажиглагааны арга хэмжээ авсан тухай (газардуулга тавьсан тухай) сануулах зориулалттай.

5. Цахилгаан гүйдэлд нэрвэгдэгчид үзүүлэх анхны тусламж

Хүн цахилгаан гүйдэлд санамсаргүй өртөх явдал элбэг тохиолддог боловч цөөн тохиолдол нь цахилгааны осолд хүргэдэг. Цахилгааны ослын дотор амьдралд оролцсон тохиолдол бага хувь эзлэх бөгөөд 140-150 мянган тохиолдлоос нэг амьдралд оролцсон осол гардаг гэсэн статистикийн мэдээ байдаг.

Цахилгаан гүйдэлд похилж амьдрын шинж тэмдэггүй болсон хүн удаан хугацаанд клиник үхлийн байдалд байдал нь олон тооны судлаачдын дүгнэлт, амьдралаар тогтоогдсон байна. Ийм учраас цахилгааны осолд орсон хүнд анхны тусламж яаралтай үзүүлэх ёстой.

Цахилгаан гүйдэлд өртсөн хүнд үзүүлэх анхны тусламж нь 2 үе шаттай байна.

Үнд:

1. Осолд орогчийг цахилгаан гүйдлээс чөлөөлөх
2. Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх

Цахилгаан гүйдэлд нэрвэгдэгчид гүйдлээс чөлөөлөх ажлыг аль болох хурдан, гэхдээ болгоомжтой гүйцэтгэх ёстой. Хэрэв осолд орогч өндөрт байгаа бол түүнийг унахаас сэргийлнэ.

Цахилгаан гүйдэлд өртөөд байгаа хүний биед шууд хүрэх нь аюултай тул аваргы өөрийгөө цахилгааны ослос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Цахилгаан гүйдэлд нэрвэгдэгчийг гүйдлээс чөлөөлөх хамгийн энгийн зөв арга нь цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжийг таслуураар нь таслах явдал юм. Цахилгааны таслах үед цахилгаан гэрэл унтарч харанхуй болох тул бусад төрлийн гэрлийн үүсгүүр бэлтгэх ёстой. Хэрэв цахилгаан гүйдлээс таслах аппаратаы тусламжтайгаар чөлөөлөх боломжгүй бол бусад аргыг хэрэглэх бөгөөд энэ нь тоног төхөөрөмжийн хүчдэлээс хамаарч олон янз байна.

1000 В хүртэл хүчдэлтэй тохиолдолд хуурай мод, пластмасс зэрэг тусгаарлагдсан барилгатай хүрч ирэхгүй сүх, хүрээ, хутга зэрэг зүйл, бахир утсыг нэг нэгээр нь тасална. Мөн осолд орогчийн хуурай хувцаснаас нь татаж салгаж болно. Харин чийгтэй нойтон хувцас эсвэл газардсан металл зүйлд хүрч болохгүй. Хэрэв хүний биед зайлшгүй хүрэх шаардлагатай бол диэлектрик бээлий өмсөх буюу хуурай материалар (хүзүүний ороолт, өөрийн хуурай хувцас зэрэг) гараа ороож барина. Мөн осолд орогчийн биеийг хүрэм, цув зэрэг хуурай даавуун материал, резинэн дэвсгэрээр бүтээж барьж болно. Хамгийн найдвартай арга нь аваргы резинэн шаахай өмсөх, эсвэл ямар нэгэн гүйдэл дамжуулдаггүй хуурай модон банз, гишүүр, резинэн дэвсгэрийг ашиглаж өөрийгөө газар буюу гүйдэл дамжуулдаг шал, сууринаас тусгаарлах явдал юм. Хэрэв нэрвэгдэгч хүчдэлтэй дамжуулалчийг гарараа атгаж зүүрсэн байвал гүйдлээс чөлөөлөгч хуурай мод, банз, диэлектрик дэвсгэр ашиглах буюу шаахай өмсөж шалнаас тусгаарлагдгах ба диэлектрик бээлий өмсөж осолд орогчийн гарын хүрүүл нэг нэгээр нь танийлгаж атгасан дамжуулалтаас чөлөөлнө. Осолд орогчийн бие дээр унасан гүйдэл дамжуулах утсыг хуурай модон

саваа, банз, бусад гүйдэл дамжуулдаггүй зүйлээр өлгөн авч холдуулан чөлөөлж болно.

**ЗӨӨВРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АЖИЛЛУУЛАХ
ҮЕД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА
АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨ:**

- Багажны бүрэн бүтэн байдал, эд ангиудын бэхэлгээний бүрэн бүтэн байдлуудыг шалгах
- Тэжээлийн кабель утас, залгуур, хамгаалалтын хоолой, бариул, хамгаалалтын бүрхүүл гэх мэт бүрэн бүтэн байдлыг шалгана.
- Хоосон явалтыг
- Гэмтэлтэй бол хэрэглэхийг хориглоно

АЖИЛЛАХ ЯВЦАД:



- Хүчдэл тасарсан тохиолдолд цахилгаан багажны тэжээлийг шалгана
- Тусгаарлах / трансформатороос зөвхөн ганцхан хэрэглэгчийг тэжээнэ/
▪ Өөрөө засварлахыг хориглоно.
- Ажиллагаа бүрэн зогстол үртэс зоргодос зэргийг цэвэрлэхийг хориглоно.
- Багажийг хүчдэлээс салгахгүйгээр потронд өрөм, хутга гэх мэт ажлын хэсгийг суулгахыг хориглоно.
- Багажны тэжээлийн кабель утаснаас барихыг хориглоно.
- Эргэлдэх хэсэгт хүрэхийг хориглоно.

АЖИЛ ДУУССАНЫ ДАРАА:

- Цахилгаан багажийг хүчдэлээс салгана.
- Тэжээлийн кабель утсыг хураана.
- Багжийг залгаатай орхихыг хориглоно.



АРВАН АЛТАН ДҮРЭМ



ГАГНУУРЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

ЦАХИЛГААН ГАГНУУРЫН АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:




- Гагнуурчин аюулгүй ажиллах арга барилыг эзэмшсэн мэргэжилийн байх
- Ажлын хувцас, бие хамгаалах хэрэгсэл, бризентэн өмд, цамц, малгай бээлий бүрэн өмссөн байх.
- Гагнуурын аппаратыг цахилгаан самбарт залгахдаа ашиглалтын зааварт заасан утасаар холбож ажиллуулах
- Гагнуурын аппаратыг засварлах ажлыг мэргэжилийн цахилгаанчин засварчинаар хийлгэх
- Гагнуурын аппаратын их биеийн газардуулгагүй, тэжээлийн утас шалбарч гэмтсэн, ашиглалтын зааварт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ажиллуулахгүй байх
- Нойтон чийгтэй хальтиргаатай газарт хамгаалалтын хэрэгсэл тоноглолгүйгээр ажиллахгүй байх
- Гагнуурчин гагнаж байгаа зүйл, гагнуурын аппаратын газардуулгыг ажлын дундуур шалгаж байх.

- Ажил дууссаны дараа гагнуурын аппаратыг цахилгаан хүчдэлээс салгаж, багаж хэрэгсэл ажлын байрыг цэвэрлэн цэгцэлж хүлээлгэн өгнө.





ГАГНУУРЫН АЖЛЫН ҮЕД ДАРААХЬ ЗҮЙЛСИЙГ ХОРИГЛОНО

- Цахилгаан тэжээлийг зориулалтын бусаар залгасан үед гагнуур хийх
- Технологийн тоног төхөөрөмж, ус түгээгүүрийн шугам, бохир усны шугамыг газардуулагчийн зориулалтаар хэрэглэх
- Хамгаалах баггүй ажиллах
- Гагнуурын аппаратыг цахилгаан шугаманд залгахдаа 500 В –с дээш хүчдэлд залгах
- Гагнуур хийхдээ өөр зүйлд анхаарлаа хандуулах, бусадтай ярилцах
- Гагнуур хийхдээ салхивчийг ажиллуулах, хаалга , цонхыг нэвт салхилуулах

Гагнуурчин нь хамгаалах хэрэгслэлийг бүрэн бүтэн өмссөн байх



Гагнуурын багаж хэрэгсэлүүд



Суурь машин дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

Машин механизм, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

- Машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг ажлын байр гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байх
- Машин механизм, тоног төхөөрөмжийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх үед мөрдөх ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар техникийн паспорттай байх
- Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж байх
- Цахилгаан тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт хамгаалалттай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон байна
- Цахилгаан тоног төхөөрөмж нь зураг төслийн дагуу угсрагдсан, газардуулга, газардуулгын даацын баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байна
- Энэ шаардлагыг хангаагүй машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

ТОКАРЫН СУУРЬ МАШИН ДЭЭР АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

АШИГЛАЛТЫН ЗААВАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГА

1. Суурь машинд хаалт хамгаалалт бүрэн байгаа эсэхийг сайн шалгаж хэрэв байхгүй бол ашиглахыг хориглоно.
2. Суурь машиныг асаахын өмнө түүны схем бүтэц бариулуудын зориулалт тэдгээрийн сэлгэн залгах журмыг сайтар мэдэж байх
3. Ажил эхлэхийн өмнө АА-ны зааварчилга авч, мөрдөж ажилла
4. 20 кг-с дээш жинтэй деталиуд бүрдэл хэсгийг боловсруулат хийхдээ өргөх төхөөрөмжийг ашиглаж бай
5. Араат дугуйнуудыг эргэж байх үед шилжүүлэн залгахыг хатуу хориглоно
6. Цахилгаан хөдөлгүүрийг асаахын өмнө удирдлагын бүх хөшүүргийг ажлын бус байдалд шилжүүлж бай
7. Боловсруулагдаж буй бүрдэл хэсэг детал зорох багажууд найдвартай бэхлэгдсэн эсэхийг шалгаж бай. Элэгдэл ихтэй төвлөрүүлэгчүүд хэрэглэхийг хориглоно.
8. Ажлын үед суурь машиныг эзэнгүй орхих үед болохгүй ямарч тохиолдолд түр завсарлах гэх мэт хөдөлгүүрийг цахилгаан хэлхээнээс салгаж бай

ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ

9. Деталийг байрлуулах авах зорих багаж солих суурь машиныг цэвэрлэх тослох үртсийг зайлуулах зэрэг ажлуудыг машиныг зогсоосон үед хийж бай.
10. Металл төмөр зорих үед жижиг үртэс үсрэх тул нүүрний хамгаалалт саравч , хамгаалалтын нүдний шил заавал хэрэглэж бай.
11. Зөөлөн металл хэсгүүдийг зорих үед жижиг үртэс зорогдос нугалах хугалах зориулалт бүхий хутга хэрэглэж бай.
12. Суурь машин дээр ажиллах үед задгай хувцастай ажиллахыг хориглоно.
Хувцсны ханцуй сул үс задгай үед машины эргэлдэх хэсэгт орооцолдох аюултай тул ханцуйвч хийх , үсийг боож малгай өмсөж ажилла.
13. Ажлын дараа үртэсийг гараар зайллуулж болохгүй дэгээ сойз хамуур зэргийг хэрэглэж бай.
14. Патрон эргэж байх үед гараар зогсоох деталльд хэмжилт хийхийг эрс хориглоно.
15. Ажлын байр дамжих замууд дээр элдэв деталлиуд овоолж орхихыг хориглоно.
16. Суурь машинд деталлыг байрлуулахдаа төвүүдийн зай зөв эсэхийг онцгой анхаарах энэ зай хангалттай биш байвал эргэлтэнд деталь мултрах унах аюултай анхаар.
17. Деталлыг патронд бэхэлсэний дараа патроноос түлхүүрийг авсан эсэхийг сайтар шалга.
18. Суурь машин дээр боловсруулагдаж байгаа деталлыг өнгөлөхдөө аюулгүй ажиллагааг хангах тохирсон хэрэгсэлүүдийг ашиглах.
19. Гагнагдсан пластыг хутгаар зорохын өмнө гагналтын чанарыг сайн шалга.
20. Хамгаалалтын газардуулгагүй суурь машин ашиглахыг хориглоно.

ГАЛЫН АЮУЛААС ХАМГААЛАХ БАГАЖ ХЭРЭГСЭЛ



ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ



АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

ДОТООД ШАТАЛТАТ ХӨДӨЛГҮҮРИЙН ЛАБОРАТОРИ




ХММ-ЫН МЕХАНИКИЙН ЛАБОРАТОРИ




ХММО- ДАДЛАГЫН ГАЗАР



ЦАХИЛГААН ЭЛЕКТРОНИКИЙН ДАДЛАГЫН ГАЗАР




ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ



ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ


ГИДРАВЛИК ХИЙ ШИНГЭНИЙ ЛАБОРАТОРИ



ГАГНУУРЫН ДАДЛАГЫН ГАЗАР



ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ



ХММ-ЫН ЦАХИЛГААН ТОНОГЛОЛЫН ЛАБОРАТОРИ



ТОКАРИЙН ДАДЛАГЫН ГАЗАР



ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ




ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ



ЛАБОРАТОРЫН КОРИДОР



ХАБЭА-ИЙН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭГ САЙЖРУУЛАХ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ГЭМТЭЛД ӨРТӨХГҮЙ БАЙХЫН ТУЛД БАЙНГА МӨРДӨЖ АЖИЛЛАХ "БҮҮ МАРТ-10"-ЫН ЗАРЧИМ

1. аюулгүй ажиллагааны зааварчлага аваагүй бол ажилд гарч болохгүйг
2. ажлын тусгай хувцас, гутал өмсөөгүй бол ажил гүйцэтгэж болохгүйг
3. хувийн хамгаалах хэрэгсэл ашиглахаа
4. ажиллагаа, техникийн байдал нь бүрэн, бүтэн бус, туршиглаагүй багаж, хэрэгсэл, машин, механизм, тоног төхөөрөмжөөр ажил гүйцэтгэж болохгүйг
5. өөрийн ажлын байраа тав тухтай, цэвэр байлгаж болзошгүй аюулаас хамгаалахаа
6. ажил гүйцэтгэх технологийг зөрчиж болохгүйг
7. ажил гүйцэтгэж байх үедээ анхаарлаа сарниулж болохгүйг
8. галын аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаа
9. хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа зөрчигдсөн тохиолдлыг харсан бол энэ тухай удирдлагадаа мэдэгдэхээ
10. үйлдвэрлэлийн осол, гэмтэл гарсан тухай удирдлагадаа мэдэгдэж эмнэлгийн анхны тусламж үзүүлэхээ

ТА БҮҮ МАРТ!




ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Ажлын байран дээр хувийн хамгаалах хувцас хэрэгслээ **ЗӨВ** хэрэглэж хэвшсэнээр учирч болох **ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЖ** чадна.

1. ТОЛГОЙ ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ
2. ИРД ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ
3. СОНСГОЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ
4. ГАР ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ
5. АМЬСГАЛЫН ЭРХТЭН ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ
6. ХӨЛ ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ

ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГЛЭЛИЙН СТАНДАРТ ТЭМДЭГЛЭГЭЭ

 Хамгаалалтын нэгдлийг өмс!	 Хамгаалалтын шил эзүү!	 Часалч хэрэгл!	 Хамгаалалтын мөсөл эзүү!
 Ажлын хувцастай өмчлөлт!	 Хамгаалалтын бэлдэг өмс!	 Ажлын гутал өмс!	 Хамгаалалтын бус эзүү!

ДҮГНЭЛТ

Энэ төсөлт дипломын ажлын хүрээнд дадлагын газрыг ХАБЭА-н шаардлагыг мөрдөн ажиллахын тулд ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажиллахад чиглэгдсэн. Тус төсөлт ажлын явцад олон төрлийн мэргэжлийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг мэдэж , судалгаа хийж сурлаа .

Үүнд: Цахилгааны аюулгүй ажиллагаа

Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

Гагнуурын аюулгүй ажиллагаа

Үйлдвэрлэлийн цахилгааны аюулгүй ажиллагаа

Токар суурь машины аюулгүй ажиллагаа

Цахилгаан ба гар багажтай ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

Түүнчлэн ажлын байрны эрсдлийг тодорхойлж , арилгаж сурлаа.

Хэрхэн ажлын байр , дадлагын газрыг аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар иж бүрэн галын булан , эмийн сан бий болгосноор оюутан суралцагчдын сурах таатай орчин , аюулгүй байдлыг бага ч гэсэн хангасан явдал болно.

Сургуулийн дадлагын газрын орчин нь үйлдвэр ба уурхайн ажлын орчинтой нийцүүлж ажиллах нь чухал болж байгаа ба суралцагч оюутан зөв ажлын хувцасаа өмсөх , аюулгүй ажиллагааг даган мөрдөх зөв дадал хандлагыг сурна.

